



ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ
ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2017 оны 05 сарын 02 өдөр

Дугаар 4/56

Улаанбаатар хот

Экспедиц ажиллуулах, нэмэгдэл
хөлс олгох тухай

Монгол улсын "Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай" хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, "Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай" хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4, "Хөдөлмөрийн тухай" хуулийн 50, 52, 53.1, 54, "Төсвийн тухай" хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4, 16.5.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Цаг агаарт зориудаар нөлөөлж хур тунадас нэмэгдүүлэх үйл ажиллагаагаа тагааг 2017 оны 5 дугаар сарын 01-ний өдрөөс 2017 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийг дуустал хугацаанд зохион байгуулж явуулсугай.

2. Цаг агаарт зориудаар нөлөөлж хур тунадас нэмэгдүүлэх экспедицийн дарга нарыг 2017 оны 5 дугаар сарын 01-нээс хавсралтын дагуу томилж, экспедиц ажиллах хугацаанд үндсэн цалингийн 40 хүртэл хувиар нэмэгдэл хөлсийг олгосугай.

3. Хур тунадас нэмэгдүүлэх үйл ажиллагааг явуулахдаа холбогдох хууль, тогтоомж, дүрэм, журам, зааврыг чанд мөрдүүлж, экспедицүүдийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг аймгуудын Ус цаг уур, орчны шинжилгээний газрын дарга нарт даалгасугай.

4. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Улсын сүлжээ, уур амьсгалын үйлчилгээний хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Пунцагдоржид даалгасугай

ДАРГА



С.ЭНХТҮВШИН